



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 4/122

Алтанбулаг

Түр хязгаарлалт тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1, 67.1.2, 67.1.3, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн санал хураалт явагдахтай холбогдуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын хэмжээнд 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 18:00 цагаас эхлэн 06 дугаар сарын 10-ны өдрийн 18:00 цаг хүртэлх хугацаанд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2. Сонгуулийн санал авах 2021 оны 06 дугаар сарын 09-ний өдөр соёл, урлаг, үзвэр, спорт зэрэг олон нийтийг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төвийг ажиллуулахыг хориглосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Одмаа), Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн дэд хурандаа (Д.Наран) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ОТГОНЦОГТ